



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/034

Мандлговь

2018 оны "Тэнгэрлэг гэр бүл"
алдаршуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.1, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөний 3.5.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт нийтлэг журам"-ын 2.1.3, Аймгийн Засаг даргын "Журам батлах тухай" 2010 оны А/526 тоот захирамжаар батлагдсан "Тэнгэрлэг гэр бүл" шалгаруулах журмын 5.3, Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 08 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гэр бүлийн уламжлалт ёс заншлыг залуу хойч үеийнхэндээ уламжлуулан өвлүүлэх, нэр хүндтэй гэр бүлийг алдаршуулах зорилгоор 2018 оны "Тэнгэрлэг гэр бүл"-үүдийг шалгаруулж, алдар цол олгох ажлыг зохион байгуулахыг Хүүхдийн төлөө аймгийн зөвлөлд даалгасугай.

Хоёр. "Тэнгэрлэг гэр бүл"-үүдийг алдаршуулах зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Шалгарсан гэр бүлүүдийг алдаршуулах ёслолын үйл ажиллагааны зардалд 360.000 (гурван зуун жаран мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Г.Мөнхбаясгалан) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О. БАТ-ЭРДЭНЭ



0200698

Аймгийн Засаг даргын 2018 оны
05 дугаар сарын 30-ны өдрийн
№ 34 тоот захирамжийн хавсралт

"Тэнгэрлэг гэр бүл"-үүдийг алдаршуулах ёслолын
үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийн тооцоо

№	Барааны нэр	Тоо, ширхэг	Нэгж үнэ	Дүн
1.	Хүндэт өргөмжлөл	5	55.000	275.000
2.	Тууз	5	7.000	35.000
3.	Хадаг	5	10.000	50.000
Нийт				360.000